

ДеФакто **тойм**

➤ ҮНДСЭН ХУУЛЬД УЛС
ТӨРИЙН НАМЫГ ЮУ
ГЭЖ ТУСГАХ ВЭ?

➤ ЗАСГИЙН ГАЗАР
БИЗНЕСИЙН ОРЧНЫГ
САЙЖРУУЛЖ БАЙНА УУ?

➤ ПУТИНЫ АЙЛЧЛАЛЫН
БЭЛТГЭЛ

VI НҮҮРТ



ДеФакто **нийтлэл**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

БАЯЛГИЙН САН 2050 ОНД

II НҮҮРТ



нийтлэл

Дэлгэрийн Уянга
Өмгөөлөгч, хууль зүйн доктор

ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ОРУУЛАХ САНАЛ -
ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ
ХАНГАХ, ОНЦГОЙ ЯЛГАРАХ
ШИЙДЭЛ

IV НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2019.09.06, №9 (113)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com





Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

БАЯЛГИЙН САН 2050 ОНД

Энэ өдрүүдэд монголчууд Үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байна. Байгалийн баялгийн эзэн нь хэн байх буюу хэн өмчлөх тухайд нэгдсэн шийдэлд хүрээгүй байна. Ард түмний, нийтийн эсвэл төрийн өмч гэж маргалдсаар УИХ болон Ерөнхийлөгчийн баг оролцсон зөвшилцөх ажлын хэсэг дээр “улсын нийтийн өмч” гэсэн холимог нэр томъёон дээр ирчихээд байна.

Нөгөө талаасаа өмч нь хэнийх ч байсан, газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялагаа ашиглах хэлбэр, хэтийн төлөвөө яаж тогтоохоо бас ярилцах шаардлагатай. Жишээ нь 30 жилийн дараа монголын баялгийн сан ямар байх юм бэ?

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТӨРЛҮҮД

Хамгийн анхны үндэсний баялгийн санг газрын тосны арвин их нөөцтэй Кувэйт улс 1953 онд байгуулжээ. Эдүгээ байгалийн баялагтай олон арван улс баялгийн сан байгуулж, хөрөнгө оруулалт нь өсөн нэмэгдэж, эдийн засагт нь амин чухал үүрэг гүйцэтгэх болсон. 2018 онд гэхэд дэлхийн баялгийн сангуудын хөрөнгө 7.6 их наяд доллар болоод байна. Үүний 1.1 их наяд нь ганцхан Норвегийн санд ногдож байна.

Баялгийн санг зориулалтаар нь таван төрөлд ангилдаг. Ихэнх улс холимог зориулалтаар ашигладаг.

Хүснэгт 1. Баялгийн сангийн төрөл ба түүний зорилго

Сангийн төрөл	Зорилго
Тогтворжуулалтын сан (Stabilization fund)	Эдийн засгийн хямрал болон түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн гарах эрсдлээс хамгаалан улсын төсвийн орлогын тогтворжилтыг хангах
Хадгаламжийн сан (Savings fund)	Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг ирээдүй хойч үедээ тэгш хуваарилахын тулд улсын орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх
Хөгжлийн сан (Development fund)	Нийгмийн хөгжлийг хангах тэр дундаа улс орны дэд бүтцийг хөгжүүлэх
Тэтгэврийн сан (Pension reserve fund)	Өсөн нэмэгдэж буй тэтгэврийн зардлыг ирээдүйд тогтвортой хангах
Хөрөнгө оруулалтын сан (Reserve investment fund)	Гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэхийн тулд уг нөөцөөр урт хугацаагаар хөрөнгө оруулалт хийх

IMF, "Sovereign Wealth Funds: Aspects of Governance Structures and Investment Management", 2013

Үндсэн хуулиндаа байгалийн баялгийг Хятад, Казахстан, Өмнөд Солонгос, Катар, Саудын Араб, Чили зэрэг улсууд төрийн өмч гэж тусгасан байна. Харин АНУ, Австрали, Канад, Швед, Финланд, Шинэ Зеланд, Австри, Франц, Энэтхэг, Сингапур, Япон, Боствана, Норвеги зэрэг орнуудад үндсэн хуулиндаа хэн нэг нь өмчлөх тухай огт заагаагүйг тэмдэглэх хэрэгтэй.


Жишээ нь Норвеги улс байгалийн баялгийг хэний өмч байх талаар үндсэн хуулиндаа тусгаагүй боловч Газрын Тостой Холбогдох Үйл Ажиллагааг Зохицуулах Хуулиндаа (Act 29 November 1996 No. 72 relating to petroleum activities) “Норвегийн төр нь газрын тосны нөөцийг эзэмших ба нөөцийг ашиглах онцгой эрхтэй” гэжээ. Сонирхолтой нь Норвеги үндсэн хуулийнхаа 112 дугаар зүйлд “байгалийн нөөцөө хойч үеийн эрхийг баталгаажуулсан, урт хугацааны бодлогод суурилан ашиглах болно” гэж оруулсан байна.



▶ НОРВЕГИЙН БАЯЛГИЙН САН

Урт хугацааны бодлогод суурилан байгалийн нөөцөө зөв удирдахын тулд Норвегийн баялгийн санг 1990 онд байгуулжээ. Энэ онд Норвеги улсын парламент Засгийн Газрын Тэтгэврийн Сангийн Тухай хуулийг батлаж энэ санг Сангийн сайд нь хариуцах, ба Сангийн яам нь шаардлагатай бүхий л шийдвэр гаргах бүрэн эрх мэдэлтэй болжээ. Сангийн яам нь Тэтгэврийн санг удирдах эрх мэдлийнхээ хүрээнд баялгийн сангийн хөрөнгийг удирдах, Сангийн яамнаас хараат бусаар хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргах эрхийг Норжес банкинд (Norges Bank) олгожээ. Улмаар хөрөнгө оруулалтын 60% нь хувьцаанд, 40% нь тогтмол орлоготой байх, үйл ажиллагаа нь ил тод нээлттэй байх, улирлын болон жилийн тайланг тогтмол гаргахыг заажээ. Мөн Сангийн яамтай яаж харилцахыг тодорхой оруулжээ.

НОРВЕГИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭВРИЙН САН



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, "Баялгийн сан, баялгийн үр ашгийг иргэдэд хүртээх нь", 2019

МОНГОЛЫН БАЯЛГИЙН САН

Монгол улсын эдийн засгийн дөрөвний нэг, экспортын 85 хувийг уул уурхайн салбар эдүгээ бүрдүүлж байгаа. Монголд байгалийн баялгийн орлогыг шударга хуваарилахын тулд хуримтлал болон тогтворжуулалтыг хослуулсан сан байгуулах нь зүйтэй.

Эрдэс баялгийг хүн биш, байгаль бүтээсэн учир, манай иргэн бүр байгалийн баялгийн орлогоос хүртэх учиртай. Гэхдээ хөрөнгөөрөө эрсдэл хүлээн тэр баялгийг хайж олсон, олборлож боловсруулсан, хэрэгцээт зах зээлд нь хүргэсэн компаниуд, хөрөнгө оруулагчид нь оролцсон хэмжээгээрээ ашгаас нь түрүүлэн хүртэж, дараа нь иргэдэд тодорхой хэлбэрээр улсын төсвөөр дамжуулан хүрэх ёстой.

Норвегийн "Төрийн глобал тэтгэврийн сан"-ийн орлого нь эхлээд улсын төсөвт цуглах газрын тосны цэвэр орлогоос (газрын тостой холбоотой бүх орлогоос Засгийн газрын энэ салбарт оруулсан хөрөнгө, зардлыг хассан) бүтнэ. Газрын тосны

бүх орлого гэдэгт, газрын тосны үйл ажиллагаанд ногдуулсан татварын бүх орлого ба роялти, газрын тосны үйл ажиллагаанаас үүдэн гарсан нүүрсхүчлийн хий, азотын исэл зэрэгт ногдуулсан татвар, лицензийн төлбөр болон төрийн эзэмшилд байсан газрын тосны хувьцааны орлого зэрэг орно. Мөн сангийн өөрийн бэлэн мөнгөний урсгалын цэвэр үлдэгдэл, тухайн жилийн хөрөнгө оруулалтын ашгаас бүтнэ. Тэгээд дараа нь төсөв алдагдалтай, эсвэл төсвөө тэлэх тохиолдолд парламентын зөвшөөрлөөр баялгийн сангаас зарцуулдаг.

Байгалийн баялгийн орлогыг харьцангуй ижил тэгш хуваарилахын тулд байгалийн баялгийн сан байгуулж, тэр сангийн удирдлага, үйл ажиллагаа нь Норвегийн баялгийн сангийн жишгээр харьцангуй бие даасан, Засгийн газраас аль болох хараат бус байх тусмаа улс төрийн нөлөөллөөс ангид, үр өгөөж нь өндөр байх магадлалтай юм.



Дэлгэрийн Уянга
Өмгөөлөгч, хууль зүйн доктор

НИЙТЛЭЛ

ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛАХ САНАЛ - ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ ХАНГАХ, ОНЦГОЙ ЯЛГАРАХ ШИЙДЭЛ

Хууль зүй, дотоод хэргийн яам Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг олон нийтээр хэлэлцүүлэхээр танилцуулжээ. Хэдийгээр олон улсын болон дотоодын хууль хоорондын ялгааг арилгах өөр бусад дэвшилтэт өөрчлөлтүүдийг санал

болгож байгаа хэдий ч “шинэ бүтээлийн түвшин агуулсан” гэсэн шалгуурт холбогдож олон улсын стандартыг бүрэн хангах жинтэй өөрчлөлт хийж чадах эсэх нь төслийн холбогдох заалтаас эргэлзээтэй байна.

ПАТЕНТ ОЛГОХ ХУУЧИН ШАЛГУУР

Монгол улсад 1944 оноос хойш үйлдвэрлэлийн техник, технологийн салбарт шинийг санаачлагчдыг төрөөс мөнгөн хэлбэрээр урамшуулж эхэлсэн. 1960, 1970 оны Сайд Нарын Зөвлөлийн холбогдох тогтоолууд нь шинэ бүтээлийн тодорхойлолт, шинийг санаачлагчийг төрөөс шагнах шалгууруудыг тодорхойлж өгсөн. 1963 оны Иргэний хууль нь орчин үеийн патентын эрх зүйн суурийг тавьсан заалтуудыг агуулж байв.

Тухайн үед төр аварга том улсын үйлдвэрүүдийг өмчилж, ажиллуулдаг байсан. Ийм эдийн засгийн зохион байгуулалтад улсын гол “толгойны өвчин” нь улсын үйлдвэрүүдийн үр ашиг, чанар, орлогын асуудал байв. Нөхөр нь эхнэртээ Австри гутал авч өгөх

гэж Улсын Их Дэлгүүрт “алалцаж” байх хооронд бусад дэлгүүрүүдийн лангуун дээр “хүн тоохгүй”, “амархан хоол нэхэж” ул нь даруй салдаг “монгол гуталнууд” ярайж байдаг байв. Иймд улсаас социализмын энэ “толгойны өвчнийг” намдаах “эм” бэлтгүүлэхийн тулд шинийг санаачлагчдыг урамшуулж байсан байна. Энэ тогтолцоонд өнөөгийн “inventive step” гэх техникийн салбарт салбарын мэргэжилтний санаанд хялбар оромгүй, онцгой сонин шийдэл олсон байх гэсэн шалгуурыг тавьдаггүй, хэрэглэдэггүй байлаа. Харин шинэ бүтээл нь улсын үйлдвэрт тустай, ашигтай, хэрэгтэй байх гэсэн улсын үйлдвэрийн ажлыг сайжруулах эдийн засаг, нийгмийн хэрэгцээний шалгуурыг тавьдаг байв.¹

1990 ОНООС ХОЙШИХ ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИУД

Монгол улс нь 1991 онд Патентын хамтын ажиллагааны гэрээ (ПХАГ) гэх өдгөө дэлхийн 152 орныг нэгтгэсэн олон улсын олон талт гэрээнд нэгдэж орсон. Энэ цагаас хойш МУ-ын Оюуны Өмчийн газар (ОӨГ) нь ПХАГ-ний олон улсын стандарт, Патентын тухай хуулийн дагуух дотоодын стандарт гэсэн хоёр зөрүүтэй стандартаар патент олгож иржээ.

ПХАГ-ний дагуу олон улсын хайлт, шүүлт хийх эрх авсан өндөр хөгжсөн орнуудын Патентын газраас олон улсын урьдчилсан хайлтын тайлан, олон улсын урьдчилсан шүүлтийн тайлан гэж гаргадаг. МУ-ын

ОӨГ энэ тайланд үндэслэж ПХАГ-ний шугамаар орж ирсэн гадаад улсын шинэ бүтээлд патент олгох эсэхийг шийддэг. Нэн ялангуяа олон улсын урьдчилсан шүүлтийн тайлан гарсан бол тэнд заасны дагуу “inventive step” шалгуурыг хангасан бүтээлд патент олгодог.

Харин гол төлөв монголчууд өөрсдөө гаргасан шинэ бүтээлийн мэдүүлэгт шинжээчийн нүдээр ямар нэг давуу шинжтэй гэж үзсэн бол “inventive step” шиг өндөр шаардлага огт тавихгүйгээр бүртгэж, патент олгох тохиолдлууд байв. ▶▶

▶ ПХАГ-НИЙ “INVENTIVE STEP” ШАЛГУУР

ПХАГ нь орчин үеийн дэлхий даяар нэвтэрсэн нэгдсэн стандарт. Үүний дагуу монголын уламжлалт тогтолцоо шиг “давуу шинж чанартай” гэсэн шалгуур тавьдаггүй. “Inventive step” шалгуур нь техникийн жинхэнэ дэвшил гаргаж, техникийн мэдлэг чадварт нэг алхам ахиц гаргасан байх шаардлага. “Нэг алхам ахиц” гэдэг нь тухайн салбарын мэдлэг, чадвартай инженер, химич зэрэг мэргэжлийн хүн нэг материалыг нөгөө материалаар орлуулах гэх мэтээр мэргэжлийн мэдлэг дээрээ тулгуурлаад бодоод олчих тийм энгийн техникийн шийдэл, шинэчлэл бус, харин хялбар бодоод олчихооргүй ер бусын санаа байх шаардлага юм. Чингэхдээ энэ нь Дорж, Дулмаад гоё үнэр, амттай байх; эсвэл “А” компанийн орлогыг нэмэгдүүлэхэд хэрэгтэй, тустай, ашигтай байхтай холбоогүй. Ер бусын техникийн шийдлийн санаа гэдэг нь оюуны бүтээл болох техникийн шинэ шийдэл, гаргалгаанд өөрт нь чиглэсэн болохоос энэ санааг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр гарах ямар нэг сайн, муу үр дагавартай холбогдолгүй юм.

ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Төслийн 5.4-т “Шинэ бүтээлийн шийдлийг патентын мэдүүлгийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнөх техникийн түвшинтэй харьцуулахад холбогдох мэргэжлийн хүний зохих мэдлэгийн хүрээнд илэрхий ялгарах давуу шинж чанартай байвал “шинэ бүтээлийн түвшин” агуулсан гэж үзнэ” гэж заажээ. Үүний “техникийн түвшинтэй харьцуулахад холбогдох мэргэжлийн хүний зохих мэдлэгийн хүрээнд илэрхий ялгарах” гэсэн хэсгийг ПХАГ-нд ойртуулж ойлгох боломжтой байгаа хэдий ч “давуу шинж чанартай” гэсэн нь эргээд хуучин тогтолцоо, ойлголтоороо хуулиа ойлгож, тайлбарлаад явах үүд хаалгыг нээж өгсөөр байна.


ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛАХ САНАЛ

Монгол улсын өнөөгийн боловсон хүчний чадварын үүднээс авч үзвэл ПХАГ-ий “inventive step” гэсэн шалгуурыг хангасан эсэхэд шүүлт хийх тийм ч хялбар биш. Нөгөө талаас Монгол улс олон улсын стандартад ойртохыг эрмэлзэж байж л патент олгох, энэ эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль зүйн ойлгомжгүй байдал, давхар стандартыг арилгах боломжтой болно. Иймээс Төслийн 5.4-ийг ПХАГ-ий 33-р зүйлийн (3)-ын үг, хэллэгт ойртуулж “Шинэ бүтээлийн шийдлийг патентын мэдүүлгийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнөх техникийн түвшинтэй харьцуулахад холбогдох мэргэжлийн хүний зохих мэдлэгийн хүрээнд илэрхий бус байвал “шинэ бүтээлийн түвшин” агуулсан гэж үзнэ.” гэж өөрчлөх саналыг үүгээр дэвшүүлж байна.²

2019 оны 9-р сар

¹ Uyanga Delger, *Das Patentrecht in der Mongolei*, p. 30

² “Илэрхий бус” гэдэг нь “not obvious” гэсэн үгийн орчуулга юм



The Defacto Gazette

НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916



ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.09.01-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ҮНДСЭН ХУУЛЬД УЛС ТӨРИЙН НАМЫГ ЮУ ГЭЖ ТУСГАХ ВЭ?

Үйл явдлын товч:

Өнгөрсөн Лхагва гарагаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлсэн. Улмаар УИХ-ын чуулганаар зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж байгаа. 150 орчим зарчмын зөрүүтэй санал байгаа. Улс төрийн намтай холбоотой асуудлаар л гэхэд гишүүдийн байр суурь ялгаатай байна. Ялангуяа Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөлд тусгасан намтай холбоотой саналаас эхлээд хэлэлцээр байна.

Дүгнэлт тайлбар:

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдээс намтай холбоотой зөрүүтэй саналууд:

УИХ-ын 62 гишүүний өргөн мэдүүлсэн төсөлд:

1. Нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.
2. Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх сурвалж болон зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болзлыг хуулиар тогтооно."

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөлд:

1. Нам нь нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодлын үүднээс сайн дураар эвлэлдсэн, нэгдмэл, тодорхой үзэл санааны хүрээнд улс төрийн үйл ажиллагаа явуулж, төрийн бодлогыг тодорхойлох зорилготой Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.
2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий тавин мянга нэгээс доошгүй тооны иргэн нэгдэж байгуулах бөгөөд гишүүний бүртгэл, өөрчлөлтийг сонгуулийн төв байгууллага хөтөлнө.
3. Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчимд нийцсэн байна. Намын удирдлага болон удирдах дээд байгууллагын сонгуулийг сонгуулийн төв байгууллага, дотоод бусад сонгуулийг холбогдох сонгуулийн байгууллага хариуцна.
4. Нам үл хөдлөх болон ахуйн хэрэгцээнийхээс бусад үнэ бүхий хөдлөх хөрөнгө өмчлөхгүй. Намын орлогын эх сурвалж, зарцуулалт нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилт, ил тод байдал болон төрөөс дэмжлэг үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно."

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөлд нам байгуулахын тулд сонгуулийн насны 50001-ээс доошгүй иргэн нэгдэж байгуулна гэсэн. Харин УИХ-ын гишүүдийн өргөн мэдүүлсэн төсөлд нам байгуулах гишүүдийн босго тоог дурдаагүй. Улмаар 2 төслийг нэгтгэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийн үеэр хоёр тал тохиролцож "сонгуулийн насны иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд нэгдэж байгуулна" гэсэн заалтыг нэмэхээр зөвшилцсөн.

Улс төрийн нам гэдэг бол иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэлбэршүүлдэг нэг төрлийн бүтэц буюу талбар. Харин тодорхой тооны ялангуяа ийм олон тооны хүмүүс нэгдэж байж л нам байгуулах ёстой гэдэг нь иргэний суурь эрхийг хөндөж байна гэсэн үг.

Дэлхийн улс орнууд нам байгуулах шаардлага, босгыг янз бүрээр тогтоодог. Манайхтай адилхан тодорхой хэмжээний хүмүүсийн дэмжлэгийг авсан гэдгээ нотлохын тулд гарын үсэг цуглуулсан байх ёстой гэдэг шаардлага тавьдаг. Гэхдээ одоогийн энэ өөрчлөлтөөр хийж байгаа шиг өндөр тоог тавьдаггүй. Зарим OSCE-гийн орнуудад нам бүртгүүлэхэд ямарваа нэг шаардлага ч тавьдаггүй. Ийм шаардлагыг хэрвээ тавьж байгаа бол хамгийн минимум хэмжээнд байлгах ёстой гэж олон улсын байгууллагууд зөвлөдөг.

Ер нь нам байгуулах шаардлага, босгыг гишүүдийн тоог тогтоож биш харин намын дүрэм журам ардчилсан зарчимд нийцсэн байх ёстой, намын нэр, бэлгэдэл, хаяг гэх мэт албан мэдээлэл нь тодорхой байх ёстой гэх зэргээр л тавьдаг.

Жишээ нь манай одоогийн Улс төрийн намын тухай хуулиар нам байгуулж, бүртгүүлэхийн тулд дараах шаардлагуудыг л тавьж байгаа.

- 9.3.1. намыг бүртгүүлэхийг хүссэн намын даргын гарын үсэг бүхий өргөдөл;
- 9.3.2. намын нэр, бэлгэдэл, далбаа;
- 9.3.3. намын дүрэм;
- 9.3.4. намын мөрийн хөтөлбөр;
- 9.3.5. намын гүйцэтгэх байгууллага байнга оршин байгаа хууль ёсны хаяг;
- 9.3.7. намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл / овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/;
- 9.3.8. намын санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий удирдах ажилтан /менежер, ерөнхий нягтлан бодох/-ны бүртгэл/ овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэх болон регистрийн

дугаар, оршин суугаа газрын болон гэрийн хаяг, гарын үсэг/

9.3.9. намын хөрөнгийн мэдээ;

9.3.10. хуульд заасан бусад баримт бичиг.

9.4. Улсын дээд шүүх намыг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш энэ хуулийн 6; 9.2- 9.3-т заасан зүйлийг нягтлан үзэж, ажлын 30 хоногийн дотор тухайн намыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох бөгөөд энэ тухай нийтэд мэдээлнэ.

9.5. Улсын дээд шүүх намыг бүртгэхдээ энэ хуулийн 9.3-т болон холбогдох хуульд зааснаас бусад баримт бичиг шаардахыг хориглоно.

9.6. Хуульд заасан шаардлагыг хангаж улсын бүртгэлд бүртгүүлснээр нам үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулах эрхтэй.

Дээрхээс харвал манайд улс төрийн нам байгуулах босго, шаардлага нь минимум хэмжээнд байгаа буюу хэлбэр, ёс төдий албан ёсны бичиг баримт, нэр хаяг шаардсан зүйлс л байна.

Ер нь бол үндсэн хуульд намын агуулгыг л тодорхойлж өгнө үү гэхээс хэлбэр, хүрээг нь тодорхойлох шаардлага байхгүй.

ЗАСГИЙН ГАЗАР БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ БАЙНА УУ?

Үйл явдлын товч:

Өнгөрсөн долоо хоногт Монгол Улсын Ерөнхий Сайд, Засгийн газрын гишүүдийн хамт бизнес эрхлэгчидтэй МҮХАҮТ-д уулзсан. Уулзалтаар Засгийн газраас нийгэм, эдийн засгийн ерөнхий төлөв байдлыг танилцуулж бизнесийн орчныг дэмжихээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн.

Дүгнэлт тайлбар:

Засгийн газрын бараг бүх гишүүд, сайд нар өөдөөс нь хараад суучихсан буюу нээлттэй илэн далангүй шууд ярилцлага болсон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

“Хууль номоороо бизнес эрхэлж яваа баялаг бүтээгчдээ бүх талаар дэмжинэ. Харин хулгай луйвар хийж, улсын баялгийг хувьдаа авч байгаа хулгайч бизнес эрхлэгчидтэй хатуу үзнэ. Улс төр, бизнесийн мафи шинжтэй болчихсон олигархуудтай ясаа цайтал хатуу тэмцэнэ гэж би амласан. Тэрийгээ ч хэрэгжүүлж эхлэж байгаа” гэж Ерөнхий сайд хэлсэн. Үүний тулд үнийг чөлөөлж бүх бизнест чөлөөтэй өрсөлдөх, ижил тэгш нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй. Төрийн компаниудыг хувьцаат компани болгох замаар иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх нь хамгийн зөв арга. Ер нь МУ-ын асуудал хууль байхгүйдээ биш хуулиа биелүүлэхгүй байгаад л байгаа.

“2018 оны бизнесийн итгэлийн судалгаагаар бизнес эрхлэгчдийн бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх хүлээлт өндөр дүнтэй гарсан. Бизнес итгэлийн ерөнхий индекс 2018 онд 0.47 гарсан нь 2012 оноос хойших зургаан жилийн хугацаан дахь анхны эерэг үзүүлэлт. Үүнээс гадна бизнесийн орчны тулгамдсан асуудал ч судалгаанд туссан. Зээлийн хүү өндөр, хугацаа богино, бодлогын тогтворгүй байдал гэсэн хоёр асуудлыг бизнес эрхлэгчид нэрлэснийг онцлох учиртай. Ер нь төр хувийн хэвшлийн харилцан ойлголцол, зөвлөлдөх механизм их чухал. Өнөөгийн байдлаас харахад төр хувийн хэвшил харилцан бие биенээ дэмжихээс гадна тулгарсан асуудлуудтайгаа хамтарч тэмцэх шаардлага үүсчихсэн. Үүнээс гадна том төслүүд дээр үндэсний компаниуд консорциум болон ажиллах байдлаар хувийн хэвшлүүд хоорондоо нэгдэн ажиллах шаардлага, боломж бидэнд бий” гэдгийг танхимын ерөнхийлөгч О.Амартүвшин онцолсон.

2019 онд Дэлхийн Банкны “Ease of Doing Business” тайлангаар Монгол Улс дэлхийн 190 орноос 67.74 оноогоор 74-т жагссан. Жил бүрийн тайланг аваад үзвэл 2018 онд 62-т, 2017 онд 64-т жагсаж байсан.

ПУТИНЫ АЙЛЧЛАЛЫН БЭЛТГЭЛ

Үйл явдлын товч:

Энэ онд Халхын голын дайны ялалтын 80 жил тохиож өмнөх жилүүдээс өргөн хүрээнд тэмдэглэж байна. Энэхүү ойг тохиолдуулан манай хойд хөрш ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 9-р сарын 3-нд Монгол улсад айлчлахаар болсон. Түүнчлэн хойд хөршийн төрийн тэргүүний айлчлалыг тохиолдуулан манай хоёр орон “Иж бүрэн стратегийн түншлэлийн тухай” гэрээг байгуулахаар тохиролцсон. Улмаар айлчлалын өмнө буюу өнгөрсөн Баасан гарагт Засгийн газар гэрээний төслийг батлаад байна.

Дүгнэлт тайлбар:

Халхын голын 80 жилийн ойд зориулж байлдааны онгоцны үзүүлбэр болсон. Энэ ямар зорилготой үзүүлбэр болсон гэж та дүгнэж байгаа вэ?

ОХУ-ын байлдааны онгоцны багийн уран нислэгийн үзүүлбэрийг доороос нь харахад үнэхээр өндөр үр чадвартай байгаа юм л даа. Гэхдээ ялалтын баяр болохоор л Оросууд зэвсгээ манай дээгүүр дэлхийд гайхуулаад байх ёстой юм уу? Энэ бүхнийг батлан хамгаалахын сайдаас асуух хэрэгтэй.



Путинь айлчлалыг тохиолдуулж нэг өдрийг амралтын өдөр болгосон. Аль нэг улсын төрийн тэргүүн ирсэн нь амрах шалтгаан мөн үү?

Амралт, ажлын өдрийг өөрчлөх асуудал жилийн өмнө л хийгдэхгүй бол хувийн хэвшилд халдаж байгаа хэрэг. Хувийн компаниуд өөрийн төлөвлөгөөтэй, ажилтай. Аль нэг амралтын өдөрт тухайн амарсан өдрийг шилжүүлсэн байлаа ч тэр өдөр нь өөр нэг ажил аль хэдийн төлөвлөгдчихсөн байдаг. Өөрөөр хэлбэл төр засаг иргэдээ хүчирхийлж байна гэсэн үг. Тэгээд ч аль нэг орны дарга ирнэ гээд хэвийн үргэлжлэх ажлын өдрийг амралтын өдөр болгоно гэдэг юу гэсэн үг вэ.

Ерөнхийлөгч В.Путин манай улсад 4 дэх удаагаа (2000, 2009, 2014, 2019 онд) ирж байгаа. Энэ хооронд Засгийн газар бараг 10 удаа солигдсон. Айлчлалын хүрээнд сүр дуулиантай ёслолын ажиллагаа болно тэгээд олон гэрээнд гарын үсэг зурна. Гэхдээ зурсан гэрээнүүдийн бодит ажил болсныг нь харвал үр дүн муу. Монголчуудын нарийн царигаар төмөр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газрын тосоо боловсруулах зэрэг олон санааг Оросууд эсэргүүцэж ирсэн. Тэгээд л аль нь ч хэрэгжээгүй. Ингээд хоосон яриад байвал ирлээ гэж хүмүүсийн ажлыг алдуулах ямар шаардлага байна.

Та “Лууван ба ташуурын бодлого: Шатахуун” нэртэй нийтлэл бичсэн. Халхын голын 80 жилийн ойг тэмдэглэх нэрийн дор авлигын шинжтэй үйл ажиллагаа нуугдаж байна уу?

2018 оны 9-р сард МУ-ын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын эдийн засгийн чуулганд оролцож ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтай уулзсан. 2019 онд Халх голын байлдааны ялалтын 80 жилийн ойг хамтран тэмдэглэх, хамтарсан үзэсгэлэн, уран сайхны ба баримтат кино, ном зохиол гаргахаар тэд тохиролцсон. Мөн манай Ерөнхийлөгч Халх гол сумыг ойн өмнө шинэчлэн байгуулах зураг төслөө Оросын ерөнхийлөгчид танилцуулсан.

Сарын дараа Оросын хамгийн том газрын тосны Роснефть компанийн гурван дэд захирал Улаанбаатарт ирж, Монголд хөрөнгө оруулж, газрын тосны эрэл хайгуул хийх, хурдан өсч буй түлш, шатахууны хэрэгцээг найдвартай хангах талаар Ерөнхийлөгчийн Тамгын Газрын дарга З.Энхболдтой уулзаад, Халх голын тулааны ойг тэмдэглэх, сумыг шинэчлэх төсөлд 10 сая доллар хандивласан. Манай Ерөнхийлөгчийн хүсэлтийг Роснефть компанийн захирал И.И.Сечин биелүүлэв. Сечин гуай сард сая долларын цалинтай ч энэ 10 сая долларыг өөрийн халааснаасаа гаргаагүй нь мэдээж.

Түүнээс хоёр долоо хоногийн дараа шинэ сумын шав тавих ёслол Дорнод аймгийн Халх гол суманд болж Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Саруул, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, сумын ИТХ-ын дарга Ц.Насанхүү, сумын Засаг дарга Х.Хүрэл-Эрдэнэ нарын албаны хүмүүс оролцсон. 2019 оны 8-р сарын эцэст хоёр Ерөнхийлөгч ирэхэд төсөл бүрэн хэрэгжсэн байхаар тохирсон.

Ер нь “улс орон бол компани биш ээ” (P. Krugman). Бизнесийн зарчмаар улс орныг удирдахад учир дутагдалтай. Аль нэг улсын ерөнхийлөгч өөр улсын ерөнхийлөгчөөс хөрөнгө мөнгө гуйхаар хүсэлтийг хүлээн авахад хэцүү, хүлээн авахгүй бол бүр хэцүү. Хэрэв тэр хөрөнгө мөнгө нь бизнесийн компаниар, ялангуяа төрийн өмчит компаниар дамжин бэлэг хандив хэлбэрээр орж ирэх нь шал өөр ашиг сонирхлыг дагуулдаг.

Роснефтийн 10 сая долларыг монголын шатахууны зах зээлийг хянах сонирхол дагажээ. Роснефть Хөшигийн хөндийн шинэ онгоцны буудлыг авиа керосиноор хангах, хуучин шинэ хоёр буудлын онгоцны түлш цэнэглэх комплексийг ашиглах урт хугацааны концессийн гэрээ яаралтай байгуулах, өөрийн шатахуун түгээх станцыг монголд барих санал тавьжээ.

Монголын улс төр-бизнесийн бүлэглэлүүд шинэ онгоцны буудлын онгоцыг цэнэглэх эрхийн төлөө ширүүн өрсөлдөж байна. Харин эцсийн дүндээ онгоцны болон машины шатахууны хангамжийг Роснефть бүхлээр нь авах үйлдэл өрнөж байна.

Улс орны шатахуун түгээх салбарыг гадаадын нэг компанид өгөх нь эдийн засгаа хараат болгох магадлал өндөр. Тиймээс Монголчууд Оросуудаас гадна, урд хөршөөсөө, эсвэл түүгээр дамжуулж авдаг үнэ өндөр ч гэсэн зүүний сүвэг шиг жижиг боломжоо авч үлдэх хэрэгтэй. Бид шатахуунаараа бяцхан ч бай, сонголттой байх учиртай.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл

www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com